



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

Дугаар 377 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө данснаас хасах,
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.5.1, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хувьчлагдсан орон сууцны байранд ногдох нийт 493 м.кв талбайтай 5,077,900.00 (таван сая далан долоон мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан газар эзэмших эрх буюу биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасч, нийтийн эзэмшилд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн өрөнхий захирал Л.Насанцэнгэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


 - 2.1. Газар эзэмших эрхийг нийтийн эзэмшилд шилжүүлэх асуудлыг хууль тогтоомж, журмын дагуу холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
 - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
 - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА
Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
372 дугаар тогтоолын хавсралт



Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй данснаас хасах
газрын жагсаалт

Д/д	Газрын нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м2	Зориулалт	Балансын үнэ (төгрөг)
1	1331900750	116	Төрийн захиргааны байгууллага	1,194,800.00
2	1331900759	127	Амины орон сууц	1,308,100.00
3	1331900774	123	Амины орон сууц	1,266,900.00
4	1331900728	127	Амины орон сууц	1,308,100.00
	Нийт дүн	493		5,077,900.00 /таван сая далан долоон мянга есөн зуун/